

## Төсөл

### ХОХИРОГЧИЙГ ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧТЭЙ УУЛЗУУЛАХ УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд байрлаж байгаа, аюул байдлын түр хамгаалалтад байгаа хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүд хүчирхийлэл үйлдэгчтэй уулзах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд байрлаж, хамгаалалтад байгаа хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүд хүчирхийлэл үйлдэгчтэй уулзах шаардлагатай бол насанд хүрсэн хохирогч өөрөө, эсхүл гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүчээр гаргаж болно.

1.3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд арван дөрвөн насанд хүрсэн өөрөө хүсэлт гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч зөвшөөрч байгааг бичгээр илэрхийлсэн байна.

1.4. Хохирогчид үйлчилгээ үзүүлж байгаа хамтарсан баг хохирогчид хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

1.5. Хамтарсан баг уулзалтын зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэх нөхцөл байдлын болон аюулын зэргийн үнэлгээг үндэслэн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзана.

#### Хоёр. Уулзалт зохион байгуулах

2.1. Уулзалтыг баг, хороо сумын нийгмийн ажилтан хариуцан зохион байгуулах бөгөөд аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хариуцна.

2.2. Хамтарсан баг нь нөхцөл байдлын болон аюулын зэргийн үнэлгээг үндэслэн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан уулзалтын зөвшөөрөл бичгээр гарган, багийн гишүүд баталгаажуулсан байна.

2.3. Цагдаагийн байгууллагын алба хаагчид уулзалтын ажиллагааны хэргийг аюулгүй байдлыг хангаж, хамтарсан багийн ажилтнууд албаны болон хохирогч, түр хамгаалагч гэр бүлийн гишүүдийн хувийн мэдээллийг нууцлах, задруулахаас урьдчилан сэргийлнэ.

2.4. Уулзалтад оролцож байгаа оролцогчид эрх бүхий ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.

2.5. Уулзалтын нэг удаагийн хугацааг 2 цагаас хэтрүүлэхгүй байхаар зохион байгуулна.

2.6. Уулзалтад оролцох хүчирхийлэгчийн болон хүчирхийлэлд өртөгчийн цагдаагийн алба хаагч үзлэг хийж сэжигтэй зүйл илэрвэл нэвтрүүлэхээс татгалзан тэмдэглэлд тусгана.

2.7. Уулзалтыг баг, хороо, сумын нийгмийн ажилтан болон цагдаагийн байгууллагын алба хаагчийн хяналтан дор явуулна.

2.8.Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд байрласан, хамгаалалтад байгаа хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүд хүчирхийлэл үйлдэгчтэй уулзсан тэмдэглэлийг уулзалт зохион байгуулсан ажилтан хөтөч уулзалтад оролцсон иргэдийн биеийн байцаалт, уулзалтын үйл ажиллагааны байдлыг тэмдэглэлд тусгаж, хамтарсан багт хүргүүлнэ.

2.9.Уулзалтыг хүчирхийлэл үйлдэгчээс хохирогчид эрсдэл учруулах байдлаар зохион байгуулна. Хохирогчид эрсдэл учрах нөхцөл байдал үүссэн үед уулзалтыг шууд зогсооно.

2.10.Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд байгаа уулзалтын камерын хяналттай байна. Хяналтын камерын бичлэгийг 30 хоногоос доошгүй хугацаанд хадгалж шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллага мэдээллийг саадгүй гаргаж өгнө.

2.11.Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд бүртгэгдэж байгаа бүртгэлд уулзалт болсон талаар тэмдэглэгээ хийнэ.

Гурав. Уулзалтын үед хориглох зүйл

- 3.1. Хохирогч сэтгэл санааны хямрал, айдастай байгаа бол;
- 3.2. Бэлгийн хүчирхийллийн хохирогч бол;
- 3.3. Хохирогч болон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлахаар бусад этгэлтэй байгаа бол;
- 3.4. Хохирогч өөрөө уулзахыг хүсэхгүй байгаа бол;
- 3.5. Уулзалтын эхлэл болон явцад хохирогч уулзалтыг цааш үргэлжүүлэхийг татгалзсан бол;
- 3.6. Эрсдэл учирч болох талаар баттай мэдээлэл ирсэн бол;
- 3.7. Хүчирхийлэл үйлдэгч нь согтуурсан буюу мансуурсан байдалтай байгаа бол;
- 3.8. Хоол хүнс, эд зүйл дамжуулах;

Дөрөв. Бусад зүйл

4.1.Уулзалт зохион байгуулсан нийгмийн ажилтан уулзалтын бүртгэлийг хөтөч Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 21.1.1 дэх заалтад заагдсан мэдээллийн санд баяжилтыг тухай бүр хийнэ.

4.2.Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтын бүртгэл хөтөч /Маягт 1/.

---oOo---

Ma

ХОХИРОГЧИЙГ ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧТЭЙ

УУЛЗУУЛАХ УУЛЗАЛТЫН БҮРТГЭЛ

Д/д		
Он, сар, өдөр		
Хохирогчийн овог, нэр		
Зөвшөөрсөн албан тушаалтны нэр, хаяг зөвшөөрлийн хуудасны дугаар		
Хүчирхийлэл үйлдэгчийн овог, нэр, хаяг, регистрийн дугаар		
Хүчирхийлэл үйлдэгчтэй ямар холбоотой		
Хяналт тавьсан цагдаа, нийгмийн ажилтны нэр		
Уулзалт хэвийн явагдсан эсэх		
Эхэлсэн цаг		
Дууссан цаг		